



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/32

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.“Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Ерөнхий боловсролын сургуулийн бага анги, 3 дугаар цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдийн дунд Монголжингоо тэмцээнийг зохион байгуулах үйл ажиллагааны зардалд 331,500 (гурван зуун гучин нэгэн мянга таван зуу) төгрөгийг зарцуулсугай.

2.Үйл ажиллагаанд зарцуулагдах 331,500 (гурван зуун гучин нэгэн мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

3.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Сугармаа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  П.ГАНЧИМЭГ

